

Living the Lotus

2
2022

VOL. 197

Buddhism in Everyday Life

Үүсгэн байгуулагчийн бодрол

Судрын хүчийг хэрхэн хүртэх вэ?

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus
Vol. 197 (2022.02)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа, Оюу-Эрдэнэ
Эхийг хянасан: Монголын РКК
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Энэ жилийн өвлийн номын уншлага эхэллээ. Үүрийн харгуйгаар хүйтнийг умартан номын өргөө рүү яаран очиж, цээж дүүрэн амьсгалаад судраа хичээнгүйлэн уншихаар дотроос эрч хүч оргилоод ирдэг билээ.


Бидний уншиж буй Цагаан лянхуа судрын үсэг бүрт бурханы хүсэл агуулагддаг. Түүнчлэн өнөөг хүртэл судрыг уншсан тоо томшгүй олон хүмүүсийн залбирал ч бас шингэсэн байдаг. Тэрхүү бурханы хүсэл, хүмүүсийн залбиралтай нэгэн сэтгэлтэй болсноор Цагаан лянхуа судрын хүч үйлчилж, ач буянаа өгдөг.

Бурханы хамгаалал гэдэг нь ер бусын нууцлаг хүч бидний хүслийг биелүүлнэ гэсэн үг биш. Аливаа зовлон бэрхшээл тохиолдсон үед Бурхан үргэлжид бидэнтэй хамт байж “Би хамгаалах учраас зүгээр ээ”, “Чамд үүнийг даван туулах хүч бий” хэмээн зоригжуулж, бидний дотоод хүчийг гаргаж өгдөг. Бурханы хамгаалал гэж үүнийг хэлнэ.

Бурхан биднийг ийнхүү хамгаалж байдагт итгэж, аливаа зүйлд хамаг хүчээ дайчилдаг байх хамгаас чухал.

«Үүсгэн байгуулагчийн үг» 10, X212-213

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.



Эд мөнгө хуримтлуулах нь: Мөнгөн өглөг (Өглөг, 2-р хэсэг)

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо

Өглөгийн үйл бол энэрэнгүй сэтгэлийн илэрхийлэл

Шагжамүни буддагийн нирваанд орсон өдөр буюу 2-р сарын 15-н дөхөхөөр олон хүн Бурхан багшийн ач буяныг санан дурсаж шинэ зүйлийг сурч мэдэхийг эрмэлздэг байх гэж бодож байна. Тэр утгаараа би ч бас Бурхан багшийн намтар түүхийг сөхөж үзвээс Шагжамүни будда шавь нартаа удахгүй нирваанд орох болсноо хэлэх үедээ айлдсан сургаал нь сэтгэлд хоногшин үлдсэн билээ. “Олон түмний сайн сайхан, аз жаргалын төлөө, хамаг амьтныг энэрэн хайрлах сэтгэлээр сургаалыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлээрэй” хэмээн захисан түүний үгнээс тэрээр хүмүүний аз жаргалын төлөө л залбирч байсан гэдгийг ойлгож болно.

Шагжамүни будда гэгээрлийг олсноос хойш хамаг амьтны төлөө сургаал түгээн дэлгэрүүлэх өглөгийн үйлийг л хэрэгжүүлсэн. Өөрөөр хэлбэл тэрээр энэрэн нигүүлсэх үйлсэд амьдралаа зориулсан юм. Түүнчлэн өгөөмөр энэрэнгүй сэтгэлийг амьдрал дээр бодит болгоё гэвэл номын өглөг, эдийн өглөг, биеийн өглөгийг хэрэгжүүлэх хэрэгтэйг тэрээр өөрийн амьдралаар дамжуулан сургасан. Тэгэхээр өглөгийн үйл гэдэг бол энэрэн нигүүлсэх сэтгэлийн үйл юм.

Нөгөөтэйгүүр өглөг гэхээр сүм хийд, шашны байгууллагад мөнгө хандивлах үйл гэсэн ойлголт нийгэмд түгээмэл байдаг. Цаашлаад эдийн өглөг, эд мөнгөний талаарх ойлголтын жинхэнэ утга учир алдагдан эндүү ташаа ойлгогдох тал ч байдаг болов уу.

Эд мөнгө хуримтлуулах нь бурханы үйл мөн үү?

Буддизмд эд мөнгийг хэрхэн тайлбарладаг талаар буддизм судлаач эрдэмтэн Накамүра Хажимэ гуай “Буддизмд эгэл сүсэгтэн олон амьдралд хэрэгцээтэй эд мөнгөнд харин ч бүр чухал ач холбогдол өгөх нь зүйтэй гэж үздэг”, “Эд мөнгө харимтлуулах нь амьдралын чухал зорилгуудын нэг юм” хэмээн өгүүлжээ. Хүсэл шуналыг хориглодог гэж ойлгогддог буддизмд хүртэл ашиг орлогын төлөө явах, эд хөрөнгө хуримтлуулж амьдрах нь байж болохгүй зүйл биш, харин ч эсрэгээрээ утга учиртай, өөдрөг тэмүүлэлтэй амьдралын хэв маяг гэж үнэлсэн байгаа юм. Учир нь эд мөнгө байж гэмээнэ хүн бусдын сайн сайхны төлөө үйл хийхийг зорьдог билээ.

Мөнгө гэдэг хэрэглэж буй хүнийхээ сэтгэлээс шалтгаалаад үнэ цэнэтэй, эсвэл үнэ цэнэгүй зүйл болж хувирдаг. Мөн мөнгийг буруу замаар ашиглах явдал ч байдаг тул хэрхэн ашиглах нь чухал. Буддизмд олсон мөнгөө олон түмний төлөө зориулах хүнийг сайшааж, хармын сэтгэлээ хаяж бусадтай хуваалцахын чухлыг онцлон сургадаг. Хичнээн их хөрөнгө цуглуулж, эд мөнгө хуримтлууллаа гээд түүнийгээ зөвхөн өөрөө л тэврээд суугаад байх юм бол тэр эд хөрөнгө ямар ч үнэ цэнэгүй зүйл болж хувирна. Харин өглөг буян хийснээр үнэ цэнэ нь гарч ирдэг ажээ. Накамүра гуай өглөгийн жинхэнэ утга учрыг ийнхүү тайлбарласан байна.

Мөнгө санхүүтэй холбоотой “эдийн засаг” гэсэн ханз үсэг Хятадын эртний судар бичигт гардаг “нийгмийг засан товхиуулж, ард иргэдийг аврах” гэсэн үгнээс гаралтай. Эндээс хуримтлагдсан мөнгийг ядуу буурай, зовлон бэрхшээлтэй тулгарсан хүмүүстэй хуваан нийгмийг засах нь эдийн засгийн тогтолцооны үндсэн ухагдахуун гэж тайлбарлаж болох юм. Мөнгө олохдоо мэдээж хэрэг хууль дүрмийн дагуу зөв шударгаар ажиллах хэрэгтэй гэдгийг хэлэхэд илүүц биз.

Сэдвээсээ жаахан хазайхад, өнөө үед цаг уурын өөрчлөлтөөс үүдэн байгаль орчинд аюул нүүрлэж, хоол хүнсний хомсдол үүсээд байгаа ба баян ядуугийн ялгаа ихсэх гэх мэт асуудлуудаас болоод олон мянган амь нас аюулд ороод байгаа билээ. Ийм нөхцөл байдалд хүмүүс бид амьдралын хэв маяг, хийх үйлдлээ засан залруулах шаардлагатай болоод байна.

Гадаадын нэгэн алдартай эдийн засагч “дэлхий ертөнцийн зүй зохистой байдлыг хангахад, мөн хүн төрөлхтний ирээдүйд хамгийн ихээр нөлөөлөх хүчин зүйл бол бусдын төлөө гэсэн зарчим юм” гэжээ. Өнөө үед хүмүүс бусадтай хуваалцах, бусдын төлөө гэсэн өгөөмөр нинжин сэтгэлтэй байхын чухлыг ийнхүү илэрхийлсэн ба улс орон, албан байгууллага ч гэсэн бусдын төлөө гэсэн үзэл санаанд тулгуурлан эвлэлдэн нэгдэж, гэгээлэг сайхан ирээдүйг бүтээцгээе хэмээн уриалсан байгаа юм. Энэ үг надад “бүх юмс нэг эх үндэстэй, нэгэн бүхэл хэмээх буддын сургаалыг ухаарч, өглөг буяны сэтгэлээр аливаа зүйлээ бусадтай хуваалцаж амьдарвал зохино” хэмээн сургаж буй Бурханы дуу хоолой мэт санагдсан.

Өнөөгийн нийгмийн нөхцөл байдлаас аваад үзсэн ч өглөгийн үйл нь хүмүүс бидний хийх ёстой нэн чухал үйл. Бурханы сургаалыг дамжуулах номын өглөг ч тэр, шаналан зовж буй хүний сэтгэлийг ойлгож тайвшруулах бие болоод сэтгэлийн энэрэн нигүүлсэхүйн үйл ч гэсэн бодьсдва хүмүүс бидний үндсэн үйл билээ.

Эдийн өглөгийн талаар нэмж хэлэхэд, түүнийг авч буй байгууллага нь юунд зарцуулах гэж байгааг сайтар нягталж ойлгох чухал. Тэгвэл жинхэнэ үнэ цэнэтэй, өөрийн болоод өрөөл бусдын төлөөх эдийн өглөг гэж чухам ямар өглөгийг хэлэх юм бол? Энэ талаар та бүхэн юу гэж боддог вэ?

“Косей” сэтгүүл, 2-р сарын дугаар


Рисшо Косей Кай Нийгэмлэг (Зурагт ном)

Үүсгэн байгуулагчийн намтар ба Рисшо Косей Кай нийгэмлэгийн түүх

Гишүүдийн тоо нэмэгдсэн нь

Дэлхийн 2-р дайн дууссаны дараа Японы нийгэм маш ядуу, ард түмний сэтгэл санаа хөсөр хаягдаж, өвчин зовлонтой хүмүүс ч олон байлаа.

Үүсгэн байгуулагч болон гишүүд “Цагаан лянхуа сударт итгэвэл аз жаргалтай болно” хэмээн сургаал түгээн олон хүнийг аварч байв. Эргэлзэнгүйгээр гишүүн болсон хүмүүс сургаалыг амьдралдаа хэрэгжүүлснээр аливааг харах өнцөг, сэтгэлээ өөрчилж чадсан ба улмаар Цагаан лянхуа сударт чин сэтгэлээсээ итгэдэг болов. Аз жаргалыг олсон гишүүд баяр хөөр, талархах сэтгэлээр сургаалыг түгээн дэлгэрүүлж, номын анд нөхдийн хүрээ өргөжин тэлэв. Ийнхүү Рисшо Косей Кай нийгэмлэгийн гишүүд улам бүр нэмэгдсэн түүхтэй.



☀ Бяцхан мэдлэг

Дайн дууссан жил буюу 1945 онд нийгэмлэг 1300 гишүүдтэй байсан бол нэг жилийн дараа 10,000, түүний дараагийн жил 18,000 болж нэмэгджээ.

Гол шүтээнийг тунхагласан нь



Мёокоо багштан нас барсны дараах жил буюу 1958 онд Үүсгэн байгуулагч “Ялж төгс нөгчсөн дуусашгүй буян үйлдэгч номын хаан Шагжамүни бурхан” бол тус нийгэмлэгийн гол шүтээн хэмээн зарлан тунхаглав. Үүнийг байгууллагын түүхэнд “Жинхэнэ үнэний тунхаглал” ч гэж тэмдэглэдэг.

Тэр жил Үүсгэн байгуулагч хойноос Хоккайдогоос авахуулаад урагшаа Кюүшү хүртэл явж анх удаа орон даяар сургаал түгээн дэлгэрүүлсэн юм. Улс даяар 48 газраар тойрон явж гишүүдтэй нүүр тулан уулзаж, Цагаан лянхуа судрын сургаалыг тайлбарлав. Энэ айлчлалаар хүмүүс Үүсгэн байгуулагчийн халуун дулаан сэтгэлийг мэдэрч, айлдварыг нь сонсоод баярлаж талархан ар араасаа гишүүн болцгоосон гэдэг.




Бяцхан мэдлэг

Тус нийгэмлэг үүсгэн байгуулагдсанаас “Жинхэнэ үнэний тунхаглал үе” хүртэлх 20 жилийг “Уран аргын эрин үе” гэж нэрлэдэг. Уран аргын тухайд зүйр үгэнд “худал хуурмаг ч бас уран арга” гэж гардаг боловч бурханы сургаалд уран арга гэдэг нь хүнийг зөв замд хөтлөх арга зам гэж сургадаг.

Хувьдаа ашиглахаас бусад тохиолдолд зөвшөөрөлгүй олшруулж, мэдээллийн хэрэгсэл дээр байршуулахыг хориглоно.





Олон улсын хэлтсийн даргын булан

Өөрийн болон өрөөл бусдын төлөөх өглөг буян

Бид энэ сард Зургаан барамидын өглөгтэй холбоотой айлдварыг үргэлжлүүлэн уншлаа. Айлдварыг уншиж тунгаангаа өглөгийн тухай ойлголтоо гүнзгийрүүлэх сайхан боломж хэмээн хүлээж авцгаая.

Шагжамүни будда өглөгийн үйлээр дамжуулан энэрэл нигүүлсэлд бүхнээ зориулан, сургаал номоо түгээн дэлгэрүүлсэн. Бид түүнээс суралцан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох өглөгийн үйлийг гүнзгий ухамсарлан хэрэгжүүлж амьдрах хэрэгтэй. Номын, эдийн болон биеэр үйлдэх өглөг дээр нэмээд эдийн бус 7 өглөг зэргийг анзаарч харвал бидэнд амьдралын бүхий л талбарт өглөг өргөх боломж үргэлж байдаг.

Мөн айлдварт эд хөрөнгийн талаар эерэгээр тайлбарлажээ. Хурааж хуримтлуулсан хөрөнгө мөнгөөрөө хүмүүсийн аз жаргалын төлөө өглөг буян хийдэг бол эд хөрөнгө хураах нь хүний амьдралын чухал зорилго болж болно хэмээсэн байна.


Тус нийгэмлэг “Нэг хоолоо хандивлая хөдөлгөөн”-ий хүрээнд хандив цуглуулж, цугларсан мөнгийг сайн дурын буяны байгууллагуудын үйл ажиллагаанд зориулдаг. Энэ нь “Эхлээд бусдын төлөө” гэсэн байгууллагын уламжлалт үзэл санаанд тулгуурласан өглөгийн нэгэн сайхан жишээ юм. Энэхүү “Косей Кай үзэл санаа” дэлхий даяар түгэн дэлгэрээсэй хэмээн чин сэтгэлээсээ хүсэн залбирна.

Акагава Кэйичи



We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: sangha@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1809 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

(Address) 1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 (Mail) POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 Email: lotusbuddhist@gmail.com
 URL: <https://sf-buddhism.org/>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rkny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

(Address) 2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 (Mail) POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809, Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-269-4567
 Email: info@rkina.org
 URL: <https://www.buddhistcenter-rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692148, San Antonio, TX 78249, USA
 TEL: 1-210-558-4430 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://rksabuddhistcenter.org>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

在家佛教韓國立正佼成會 Korean Rissho Kosei-kai
〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

**在家佛教韓國立正佼成會釜山支部
Korean Rissho Kosei-kai of Busan**
〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人 在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Taipei
台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會 Rissho Kosei-kai of Tainan
台灣台南市東區崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu
Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai Society of Kolkata
89 Srirampur Road (VIP), Garia, Kolkata 700084, India

Rissho Kosei-kai of Kolkata North
AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center
Ambedkar Nagar, West Police Line Road, Rampur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center
Please contact Rissho Kosei-kai Society of Kolkata

Rissho Kosei-kai of Central Delhi
77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Phnom Penh
W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia
Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok
Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation
No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa
Please contact Rissho Kosei Dhamma Foundation

Rissho Kosei-kai Bangladesh
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL: 880-2-41360470

Rissho Kosei-kai Mayani
Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama
Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria
Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni
Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Raozan
Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham
Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka North
408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar
Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Please contact Rissho Kosei-kai Bangladesh

Rissho Kosei-kai Patiya
Rissho Kosei-kai Ramu
Rissho Kosei-kai Aburkhill

Buddiyskiy khram "Lotos"
4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong
Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai of Ulaanbaatar
(Address) 15F Express Tower, Peace avenue, khoroov-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia
TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet
Please contact Rissho Kosei-kai International

Rissho Kosei-kai di Roma
Via Torino, 29, 00184 Roma, Italia
TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Please contact Rissho Kosei-kai di Rome

Rissho Kosei-kai of Paris
Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of the UK
29 Ashbourne Road, London W5 3ED, UK
TEL: 44-20-8933-3247 Email: info@rkuk.org URL: <https://www.rkuk.org>
Facebook: <https://www.facebook.com/rkuk.official>
Twitter: https://twitter.com/rkuk_official
Instagram: https://www.instagram.com/rkuk_official

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)
166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F
Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan
TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.ibt-rk.org>